




МУИС-ийн ОЮУТАН
МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ

Мэдээ-1

2016 он



ОЮУТАН ТАНЫ СУРГАЛТЫН ТӨЛБӨР ЮУНД
ЗАРЦУУЛАГДДАГ ВЭ?

МУИС-ийн оюутны төлбөр: бүтэц, хэмжээ

МУИС-ийн Удирдах зөвлөл сургалтын төлбөрийг энэ онд нэмэхгүй өмнөх жилийн хэмжээнд барих шийдвэр гаргалаа.

2016-2017 оны хичээлийн жилд МУИС-ийн бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцаж буй оюутан суралцагсдын төлбөр нь дараах байдалтай байна.

Бакалаврын хөтөлбөрийн оюутнууд:

1. Сургалтын суурь төлбөр буюу нэг хичээлийн жилд 224,000 мянган төгрөг,
2. Багц цагийн төлбөр (дунджаар нэг багц цаг 74,269 мян.төгрөг.)

МУИС-ийн ахисан түвшний хөтөлбөрийн оюутан суралцагсад:

1. Сургалтын суурь төлбөр нэг хичээлийн жилд 336,000 мянган төгрөг,
2. Багц цагийн цагийн төлбөр: дунджаар нэг багц цаг
-Докторант, 128,000 мян.төгрөг
-Магистрант 103,000 мян.төгрөг байна.

**МУИС-ийн төсвийн хэдэн хувийг оюутны төлбөр
эзэлдэг вэ?**

2016 оны байдлаар сургалтын төлбөрөөс орж буй орлого МУИС-ийн нийт төсвийн 54,5 хувийг эзэлж байна.

МУИС-ийн сургалтын төлбөр яагаад а. Сургалтын суурь үйлчилгээний төлбөр, б. Багц цагийн төлбөр гэсэн бүрдлээс хэсгээс бүрддэг вэ?

Их дээд сургуулиуд сургалтын төлбөрийг тогтоохдоо харилцан адилгүй аргачлалыг ашигладаг. Зарим их дээд сургууль төлбөрийг ялган ангилахгүйгээр багц цагийн төлбөрт бүх үйлчилгээнийхээ зардлыг багтаан тооцдог. Ингэснээр оюутан суралцагчид ямар нэг үйлчилгээг авсан эсэхээс үл хамааран төлбөр төлөх бөгөөд дахин судлах, шинээр судлах хичээлүүдийг үзэхдээ ч суурь үйлчилгээний зардлаа давхардуулан төлөхөд хүрдэг.

МУИС нь төлбөрөө бүрдэл хоёр хэсэгт хувааснаар оюутан зөвхөн өөрийн авч байгаа үйлчилгээнийхээ төлбөрийг жилээр болон улирлаар хуваан төлөх боломж бүрддэг. Оюутан сонгосон хичээлийн багц цагийн төлбөрийг төлөхдөө үйлчилгээний зардлыг давхардуулан төлдөггүй нөхцлийг бүрдүүлж өгдөг давуу талтай.

Сургалтын төлбөрийг юунд зарцуулдаг вэ?

Сургалтын суурь үйлчилгээний ТӨЛБӨР нь оюутны сурах үйл ажиллагааг дэмждэг нийтлэг үйлчилгээний дараах зардлыг САНХҮҮЖҮҮЛДЭГ. Үүнд:

МУИС-ийн эрдмийн хамт олон багш профессор, бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн оюутнуудад үзүүлдэг төвлөрсөн үйлчилгээ -Номын сан: ном бүрдүүлэлт, олон улсын сэтгүүлийн онлайн эрх, номын сан болон оюутны бие даах төвийн ажилтаны цалин хөлс, мэдээлэл, программ хангамж, сургалтын үйл ажиллагаатай холбогдсон нэгдсэн үйлчилгээ, оюутны үйлчилгээ, сургалтын нэгдсэн алба, оюутны алба болон захиргаа, удирдлагын зардлын тодорхой хувь хэмжээ, оюутны байгууллага, клубын зардалд зарцуулдаг

Сургалтын орчинг сайжруулах -Хангамж үйлчилгээний алба, үйлчилгээний ажилчдын цалин хөлс, үйл ажиллагааны зардал, МУИС-ийн хөрөнгөөр хийж буй барилга байгууламж; оюутны болоод хичээлийн анги танхимын их ба урсгал засвар, сурах орчны тохижилт, сургалт, судалгаа болоод бусад тоног төхөөрөмж ТЭХ-ын элэгдэл орно.

Оюутны мэдээллийн үйлчилгээ: Оюутны гарын авлага, холбогдох мэдээлэл, Мэдээлэл технологийн албаны ажилтнуудын цалин хөлс, үйл ажиллагааны төсөв, сургалтын Си Си системийн үйл ажиллагаа, програм хөгжүүлэлт, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл багтана.

Багц цагийн төлбөрөөс МУИС дараах зардлыг САНХҮҮЖҮҮЛДЭГ. Үүнд:

Оюутны сурах үйл ажиллагаанд шууд холбоотой сургалтын үйлчилгээ: багш профессорууд, салбар сургалт,

МУИС-ийн захиргаа, Оюутны алба

оюутны албадын мэргэжилтэн, зааварлагчдын цалин хөлс үйл ажиллагааны зардал, хээрийн болон үйлдвэрлэлийн дадлага, сургалтын үйлчилгээний ажилчдын цалин хөлс, хичээл практик, эрдэм шинжилгээний хурал семинарын зардал, оюутны академийн үйлчилгээ, гадаад багш болон багшийн үйл ажиллагаа, хөгжлийг дэмжих зардал, сургалтын тоног төхөөрөмж, эд хогшлын зардал.

Оюутанд олгодог тэтгэлэг, үндэсний болон олон улсын олимпиад, оюутны дунд зохиогддог бүх төрлийн уралдаан тэмцээний зардлыг төлбөрийн энэ бүрдлээс санхүүжүүлдэг байна. МУИС нь жил бүр сурлага, эрдэм шинжилгээ, урлаг спортоор бусдыгаа хошуучлан сургууль, хамт олныхоо нэрийг эх орон, олон улсад мандуулсан тэргүүний оюутан суралцагчдаа тэтгэлэг олгодог бөгөөд зөвхөн 2015-2016 оны хичээлийн жилд нийт 337 оюутан МУИС-ийн тэтгэлгийг хүртсэн байна.

Сургалтын төлбөрийг хэн, ХЭРХЭН баталдаг вэ?

Монголын улсын боловсролын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу МУИС-ийн Удирдах зөвлөл нь сургалтын болоод оюутны дотуур байрны төлбөрийн хэмжээг шийдвэрлэн тогтоодог.

Удирдах зөвлөлд төрийн төлөөллөөс гадна багш нарын, оюутны болон төгсөгчдийн төлөөлөл ордог.

**Сургалтын болон оюутны үйлчилгээг
сайжруулах, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх
талаар ямар ажил хийж байгаа вэ?**

МУИС нь оюутанд үйлчлэх үйлчилгээг чанартай соёлтой болгоход онцгой анхаарч ажиллаж байна. Энэ хичээлийн жилээс МУИС-ийн Үйлчилгээний нэгдсэн стандарт хэрэгжиж эхэлнэ. Дотуур байрны журам шинэчлэгдэн батлагдлаа. Шинэ хичээлийн жилд нийт ажилтан албан хаагчдын үйлчилгээний соёлыг дээшлүүлэх сургалт явуулах, үзүүлж буй үйлчилгээ, харилцааны чанар, соёлын талаар оюутны санал бодлыг судалж, гомдлын мөрөөр арга хэмжээ авах, нийт ажилтнаа энгэрийн тэмдэгтэй болгож, нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлж, аливаа лавлагаа, тодорхойлолтыг оюутан өөрөө ТҮЦ машинаас авдгийг улам боловсронгуй болгож байна.

Оюутан та сонирхсон мэдээллээ дараах хаягаар авч болно.

Оюутны Төв алба

МУИС-ийн хичээлийн 1-р байрны 219 тоот өрөө

Холбоо барих утас: 75754400, 1143, 1144

E-mail: studentaffairs@num.edu.mn

ШУС оюутны албаны мэргэжилтэн

МУИС-ийн хичээлийн 2-р байрны 200 тоот өрөө

Холбоо барих утас: 75754400, 2112

E-mail: studentaffairs1@num.edu.mn

ХШУИС оюутны албаны мэргэжилтэн

МУИС-ийн захиргаа, Оюутны алба

МУИС-ийн хичээлийн 3-р байрны 212 тоот өрөө

Холбоо барих утас: 75754400, 3106

E-mail: studentaffairs2@num.edu.mn

Бизнесийн сургууль оюутны албаны мэргэжилтэн

МУИС-ийн хичээлийн 4-р байрны 203 тоот өрөө

Холбоо барих утас: 75754400, 4104

E-mail: studentaffairs3@num.edu.mn

**Хууль зүйн сургууль сургууль оюутны албаны
мэргэжилтэн**

МУИС-ийн хичээлийн 3-р байрны 206 тоот өрөө

Холбоо барих утас: 75754400, 3501

E-mail: studentaffairs4@num.edu.mn


ОУХНУС оюутны албаны мэргэжилтэн

МУИС-ийн хичээлийн 5-р байрны 201 тоот өрөө

Холбоо барих утас: 75754400, 5103

E-mail: studentaffairs5@num.edu.mn

Хичээлийн байр, оюутны байрны байршил



МУИС-ийн захиргаа, Оюутны алба